

**ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТАД
ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ**

Б.Нямдаваа

ДХИС-ийн Удирдлагын академийн 8021 доттп дамжааны суралцагч,
цагдаагийн хошууч.

Nyamdavaa.B

Master student in the 8021th course of Leadership Academy of the University
of Internal Affairs, Mongolia, police major.

Товч агуулга:

Монгол Улсын Цагдаагийн байгууллагад эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх чиглэлээр хэрэгжиж буй хууль, дүрэм, журамд дүн шинжилгээ хийж, олон улсын стандарт, дүрэм, журам, сайн туршлагыг байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлэх чиглэлээр шинэ, санал, санаачилга дэвшүүлэхэд оршино.

Brief content:

The goal is to analyze the laws and regulations that are implemented in the field of risk management in the Mongolian Police organization, and to propose new proposals and initiatives for the introduction of international standards, regulations, and good practices in the organization's operations.

Түлхүүр үгс:Цагдаагийн байгууллага, байгууллагын эрсдэл, эрсдэлийн удирдлага, эрсдэлийн үнэлгээ,

Key words:Police organization, Organizational risk, Risk management, Risk assessment,

Оршил.

Цагдаагийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.9 дэх хэсэгт “цагдаагийн байгууллага, алба хаагч, ажилтны аюулгүй байдал, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах”;

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор “Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг баталсан. Тус баримт бичгийн 7 дугаар зорилтын **7.3 дахь хэсэгт** “Уламжлалт бус аюулын эрсдэлийг бууруулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чадавхыг бэхжүүлж, хүн-нийгмийн амар тайван орчныг

бэхжүүлнэ”, мөн 7.3.16 дахь хэсэгт “Аюулын төрөл бүрээр гамшгийн эрсдэлийг үнэлэх арга, аргачлал, загварчлал боловсруулж, эрсдэлийн үнэлгээ хийнэ”;¹

Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөрийн 3 дугаар бүлгийн 3.2.3.1 дэх хэсэгт “цагдаагийн төлөвлөлтийн чиг үүргийн хүрээнд стратегийн, хөтөлбөрийн, шийдвэр гаргалтын, инновацийн, төслийн, маркетингийн, өөрчлөлтийн, харилцааны, эрсдэлийн, цагийн удирдлагын аргуудыг нэвтрүүлэх”, мөн 3.2.5.3 дахь хэсэгт “цагдаагийн байгууллагын гүйцэтгэлийн болон эрсдэлийн удирдлагын тогтолцоог сайжруулах”;² гэж тус тус заажээ.

Дээрх зорилтуудтай уялдуулан байгууллагын зорилго, зорилтыг хангах, учирч болох эрсдэлийг магадлал ба нөлөөллийн аргачлалаар үнэн бодитоор тодорхойлж, эрсдэлийг бууруулах, сөрөг үр дагаврыг арилгах, хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь байгууллагын эрсдэлийн стратегийн зорилт юм.

Судалгаагаар цагдаа, дотоодын цэргийн байгууллага, алба хаагч нь Монгол Улсын 119 хуулийн 1637 заалт, 285 дүрэм, журмын хүрээнд 6700 гаруй үүрэг хүлээдэг, тэдгээрийн 40 орчим хувь нь доголдолтой, уялдаа холбоогүйн улмаас тус байгууллагын ажлын ачаалал жилээс жилд нэмэгдэж иргэдэд хүрэх үйлчилгээний чанарт нөлөөлж ирсэн³.

Мөн байгууллагын бүтэц, удирдлага, зохион байгуулалт, хүний нөөцөд хомсдол үүсч функцийн гүйцэтгэлийн хувьд гацах, үр дүн, бүтээмжийн зогсонги байдалд хүрэх эрсдэл бий болсон тул дунд хугацаандаа хөндлөнгийн мэргэжлийн байгууллагатай хамтран бүтцийн шинэчлэл, өөрчлөлт хийх, урт хугацаанд зохиомол ачааллыг багасгаж, үр өгөөжтэй бүтцийг бий болгох, хүний нөөцийн тогтвортой байдлыг хангаж, цалин хөлсийг бусад ижил чиг үүргийн байгууллагатай уялдуулан нэмэх шаардлагатай гэж дүгнэсэн⁴.

Цагдаагийн байгууллагын дунд шатны нэгжийн удирдлагын бүрэлдэхүүн нь ажил үүргийн давхардалтай, хүнд суртлын болон анхан шатны алба хаагчдаа ажлын ачааллаар дардаг, анхан шатны нэгжийн иргэдтэй шууд харьцаж ажилладаг ажил, албан тушаалын хүрэлцээгүй явж ирсэн, нөгөө талаар ажлаа мэддэг, туршлагатай алба хаагчдад бүх ачааллыг үүрүүлдэг нь шимэгч тогтолцоог бий болгосон гэсэн судалгааны дүгнэлт гарчээ.

Түүнчлэн ажилтан, алба хаагчдын 91.2 хувь нь банкны зээлтэй, өдөр тутам ажлын цаг 30 хувийн хэтрэлттэй, тухайлбал, бүх нийтийн баяр, амралтын

¹ Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоол. “Алсын хараа 2050” урт хугацааны бодлогын баримт бичиг-Уб.,2020.

² Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 141 дүгээр тогтоол. Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр-Уб.,2020.

³ “Залуу судлаачдыг дэмжих сан ТББ”, Цагдаагийн албаны үйл ажиллагаан дахь иргэдийн сэтгэл ханамжийн түвшинг тодорхойлох судалгаа-Уб.,2023.

⁴ Максима судалгааны төв., Цагдаагийн ажиллах нөхцөл боломж, ажлын ачаалал, ажил мэргэжилдээ хандах хандлагын судалгаа-Уб.,2022.

өдрүүдийн талаас илүү хувьд нь бүрэн бүрэлдэхүүнээрээ ажилладаг, нийт бүрэлдэхүүний 61.9 хувь (27.5 хувь нь цусны даралт, 10.7 хувь нь бөөр, 6.1 хувь нь ходоод, 6.3 хувь нь чихрийн шижин, 5.0 хувь элэгний вирусийн гаралтай үрэвсэл, хатуурал, 5.5 хувь нь нурууны эмгэг) өвчлөлтэй, нас баралтын эрсдэл их байгааг онцолсон.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2014-2024 онуудад нийт 14 удаа эрсдэлээ тодорхойлж, үнэлгээ хийж Хууль зүй, дотоод хэргийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт хүргүүлсэн. Байгууллагын хэмжээнд 2021, 2022 онд нийт 3299 эрсдэл тодорхойлогдож ICS программд шивэгдсэнээс 2022 онд “Ач холбогдлын зэрэг”-ээрээ “Их” буюу “Эрсдэлийн тоон түвшин”-ээр 20-25 оноогоор үнэлэгдсэн 40 төрлийн эрсдэл бүртгэгдсэн.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2023 онд 55 нэгжийн 558 эрсдэлд үнэлгээ хийж, цагдаа, дотоодын цэргийн байгууллагын эрсдэлийн мэдээллийн (2014-2023он) цахим санд оруулж, “Их” буюу “Эрсдэлийн тоон түвшин”-ээр 25 оноотой 12 төрлийн эрсдэлийг Хууль, зүй дотоод хэргийн яаманд мэдээлжээ¹.

Иймд байгууллагынхаа эрсдэлийг үнэн бодит байдлаар тодорхойлж, хариу менежментийн төлөвлөгөөг авч хэрэгжүүлэх, мэдлэг, чадварыг эзэмших хэрэгцээ, шаардлага удирдлагад тулгарч байна.

Түүнчлэн цагдаагийн байгууллага нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхдээ байнгын эрсдэл, аюултай тулгардаг тул эрсдэлийн удирдлагын тогтолцоог онол, арга зүйн үндэслэлтэй үйл ажиллагаандаа нэвтрүүлснээр байгууллага, алба хаагчийн аюулгүй байдал хангагдаж, эрсдэл, аюул, ослоос урьдчилан сэргийлэх, байгууллагын хэвийн үйл ажиллагаа хангагдах зэрэг олон талын эерэг ач холбогдолтой тул энэхүү сэдвээр судалгааны ажил явуулахаар сонгосон болно.

Үндсэн хэсэг

Аливаа байгууллагын удирдлагын үндсэн үүрэг бол эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх явдал юм. Орчин үед эрсдэлийн удирдлага нь аливаа байгууллагын үйл ажиллагааны чухал бүрэлдэхүүн хэсэг болсон. Эрсдэлийн удирдлагыг оновчтой хэрэгжүүлж чадаагүйн улмаас байгууллага зорилгодоо хүрч чадахгүй байх, үйл ажиллагаа саатах, ихээхэн хэмжээний хохирол амсах, алба хаагч, ажиллагсдын эрх ашиг, эрүүл мэнд зөрчигдөх зэрэг сөрөг үр дагаврууд үүсэх шалтгаан болж байдаг. Иймд эрсдэлийг өдөр тутам тооцоолж, удирдаж байх хэрэгтэй.

¹ Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2022, 2023 оны эрсдэлийн үнэлгээний тайлан.

Германы тэрбумтан Бодо Шефер хэлэхдээ: “... Амьдрал гэдэг үргэлж уянгалаг, гэгээн нотоор бичигдсэн симфони биш шүү дээ! Энд бараан, гүн хар нүргээн ч тохиолдоно. Хэн өөрийн үнэ цэнийг ухамсарлана, тэр бэрхшээлээс айх шаардлагагүй...” гэж хэлсэн байдаг.

Үнэхээр амьдрал бол тэмцэл. Амьдралд сайн, муу, сайхан, муухай зүйл байнга тохиолддог. Эрсдэлгүй амьдрал гэж огт байдаггүй. Эрсдэл нь нийгмийн аль ч салбарт байгууллага, хувь хүнд тохиолдох боломжтой саад бэрхшээл бөгөөд үүнийг урьдчилан тооцож, хохирол багатай даван туулах шаардлагатай.

Эрсдэл гэдэг нь хэл зүйн үүднээс авч үзвал The Oxford англи хэлний толь бичигт 1621 онд эрсдэл гэдэг үгийг *risque* гэж бичиж хэрэглэж ирсэн бөгөөд 1965 оноос *risk* гэж бичиж хэрэглэдэг болжээ. *Risk*-г тайлбарлахдаа алдагдал, гэмтэл, таагүй нөхцөл байдал үүсэх магадлал гэжээ¹.

Эртний *Ridsikon* гэсэн грек үг, *ridicare* гэсэн латин (хадны завсар хавчуулах) үгнээс гаралтай боловч англи хэлний *risk*, орос хэлний *риск* гэсэн үгнүүдийг 1994 оноос эхлэн эрсдэл гэж орчуулан хэрэглэх болсон².

Судлаачдын бүтээл, хэл зүйн тайлбар толь, монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй дүрэм, журам, стандартаас үзэхэд эрсдэлийн тухай ойлголт нэг мөр болоогүй, судлаачид өөрсдийн үзэл баримтлалыг иш үндэс болгон тайлбарлаж байна.

Эрсдэл нь “болзошгүй аюул”³, “аюул, болзошгүй алдагдал буюу хохирол”⁴, “тодорхой ажиллагааны буюу шийдвэрийн үр дүнд сөрөг үр дагавруудтай үйл явдал эхлэх боломж”⁵, “ямар нэг муу зүйл тохиолдох магадлал”⁶, “Зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлдэг, тохиолдох хугацааг нь урьдчилан тооцох боломжгүй саад, бэрхшээлийг хамтад нь эсвэл тусад”⁷, “зорилтыг тодорхой бус болгож байгаа үр нөлөө”⁸, “тодорхойгүй байдал буюу урьдчилан тооцоолоогүйгээс үүсэх хохирол”⁹ “тухайн байгууллага хууль тогтоомжийн хүрээнд чиг үүрэг, зорилго, зорилтоо хэрэгжүүлэхэд гарч болох

¹ Нурмаа,Т.Шүүхийн шинжилгээний байгууллагын үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан дотоод аудитыг хэрэгжүүлэх нь- УБ., 2019. 20 дахь тал

² Доржнамжил,Д. Баярцэцэг,О. нар Эрсдэлийн удирдлагын арга түүний хэрэгсэл, хэрэглээ-УБ.,2013 он., https://prezi.com/pu839qwhg2_/presentation/

³Цэвэл,Я. Монгол хэлний тайлбар толь-УБ.,1966.

⁴ Уэбстер,Н. Англи хэлний толь-1828.

⁵ Эдийн засгийн дэлгэрэнгүй толь-УБ.,1998.

⁶ <https://en.wikipedia.org>.

⁷ Викитоль бичиг.

⁸ Монгол Улсын MNS ISO 31000:2020 “Эрсдэлийн удирдлагын стандарт”-УБ.,2020.

⁹ Үндэсний хөгжлийн газрын даргын 2020 оны А/96 тоот тушаалын 3 дугаар хавсралт-УБ.,2020.

сөрөг үр дагавар, тодорхой бус байдал, тулгамдсан асуудал”.¹ “зорилго, зорилтдоо хүрэхийн тулд зайлсхийх шаардлагатай тодорхой бус байдал, үр дагавар, гэнэтийн гарз хохирол учруулж болзошгүй үйл явдал”² гэх мэтээр тайлбарласан байна.

Дээрх тайлбар, тодорхойлолтыг “Залуу судлаач төрийн бус байгууллага”-аас боловсруулсан системийн инженерийн аргачлалыг ашиглан тодорхойлоход “эрсдэл” гэдэг нь байгууллага, хувь хүн зорилгоо хэрэгжүүлэх үйл ажиллагаанд сөрөг нөлөө учруулж болзошгүй тохиолдох магадлал бүхий аливаа үйл явдал, нөхцөл байдал”, “эрсдэлийн удирдлага” нь үйл ажиллагаанд үзүүлж болох сөрөг нөлөөллийг бууруулах, боломжит эрсдэлүүдийг хянах, түүнийг шийдвэрлэх арга замыг тодорхойлох, урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэгжүүлдэг менежментийн стратеги гэж үзэхээр байна.

Эрсдэлийн удирдлага нь байгууллагын менежмент, стратеги болон шийдвэр гаргах үйл явцын салшгүй нэг бүрэлдэхүүн хэсэг бөгөөд байгууллагад нэвтрүүлснээр байгууллагын зорилго, зорилтдоо хүрэх магадлал өндөрсөх, аюул болон боломжуудыг илүү сайн тодорхойлох, байгууллага, алба хаагчийн үйл ажиллагааг эрх зүйн зохицуулалт, олон улсын норм, стандартад нийцүүлэх, шийдвэр гаргалт, төлөвлөлт үндэслэлтэй бодитой болох, төлөвлөгөөгүй алдагдал, зардал буурч байгууллагын бүтээмж нэмэгдэх, алба хаагч, ажиллагсдын эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, үүрэг гүйцэтгэл сайжрах, хяналтын үйл ажиллагааны үр дүн, үр ашигтай байдал дээшлэх ач холбогдолтой.

Эдгээрийн үр дунд үйл ажиллагааны үр ашиг сайжирч, зохион байгуулж буй ажил, арга хэмжээнүүд үр дүнтэй болж, байгууллагын хүрсэн зорилго, зорилтуудын үр нөлөө улам бүр нэмэгдэнэ. Эрсдэлийн удирдлагыг үр дүнтэй хэрэгжүүлбэл дараах ач холбогдолтой. Үүнд:

- Байгууллагын үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаанд гол анхаарлаа хандуулах боломжийг олгохоос гадна үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах замаар төлөвлөлтийн үйл явцыг сайжруулдаг;
- Гэнэтийн, төлөвлөлтгүй зардал бүхий эрсдэлийн магадлалыг бууруулж, сорилт бэрхшээл, таагүй үйл явдал, үр дагаврыг арилгахад тусалдаг;
- Хамгийн ноцтой, дээд түвшний эрсдэлд илүү анхаарал хандуулж, нөөцийг чиглүүлэх замаар нөөц хуваарилалтыг сайжруулдаг;
- Байгууллагын үр ашиг, үйл ажиллагаа, зорилтын биелэлтийг мэдэгдэхүйц хэмжээнд сайжруулдаг;

¹ Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны А/120 дугаар тушаалын хавсралт-У6.,2022.1 дэх тал

² Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх код-137-У6.,2024.

- Хүмүүс болон байгууллагын нэгжүүд зорилго, чиг үүргээ илүү сайн ойлгосноор байгууллагын эерэг соёл, хандлага бий болдог;
- Байгууллагын даргын шийдвэр гаргах, үр дунд хүрэх үйл ажиллагааг илүү хариуцлагатай, ил тод, нээлттэй, уялдаа холбоотой үндэслэлтэй болгодог;
- Байгууллагын шийдвэр гаргалт, төлөвлөлт, бодлого боловсруулалт, гүйцэтгэл болон нөөцийн хуваарилалтад бодит дэмжлэг үзүүлж байгууллагын засаглалыг тасралтгүй сайжруулах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлдэг¹.

Эрсдэлийн удирдлагын чиглэлээр анх 1921 онд Франк Найт(Frank Knigh) “Эрсдэл тодорхойгүй байдал ашиг” гэсэн номоо хэвлүүлсэн нь одоогийн эрсдэлийн удирдлагын суурь болсон байна. 1921 онд Жонни Мейнард Кейс(John Maynard Keynes) “Магадлалын номлол” бүтээлдээ их тооны хуулийг үл харгалзан магадлалыг тооцохдоо хүртэхгүй, сэтгэмжийн уялдаа холбоог тодорхой болгох нь чухал санааг гаргаж байсан нь эрсдэлийг хэмжих анхны онолын судалгаанд тооцогддог.

Эрсдэлийн удирдлага нь даатгалын салбарт түлхүү хөгжиж ирсэн бөгөөд 1931 онд АНУ-ын удирдлагын холбооны дэргэд Даатгалын хэлтсийг байгуулсан байна. Энэ үед эрсдэлийн менежерийн албан тушаал бий болжээ. Эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа нь эрсдэлийн хэмжээг тооцох төдийгөөр хязгаарлагдахгүй удирдлагын бүрэлдэхүүн хэсгийн хувьд тасралтгүй үргэлжлэх үйл явц юм².

АНУ-д 1950-иад оны үед өндөр хураамжтай, хамгаалалт муу даатгалын систем үйлчилж эхэлсэн ба үйлдвэр эрхлэгчид өөрсдөө эрсдэлээ үүрэх үүрэг хүлээж, хамтын дундын эрсдэлийн схем үүсгэх гэсэн чиглэлд шилжсэнөөр даатгуулагчид эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлд онцгой анхаарах шалтгаан болсон. Энэ үеэс эхлэн эрсдэлийн удирдлага гэх санаа, нэр томьёо зэрэгцэн гарч ирсэн. 1970 оны үед Санхүүгийн эрсдэлийн удирдлагын хувьсал үнэ, ханшийн савлагаа, хүүгийн түвшин, хувьцааны захын өгөөж, ханшийн эрсдэл, түүхий эд материал бараа таваарын үнийн өөрчлөлтүүд зэргээс шалтгаалж санхүүгийн эрсдэлийн удирдлага нэн чухал болж хөгжсөн.

Энэ үед олон улсын хэмжээнд өргөн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг корпорацууд бий болсон хэдий ч нэгжүүд нь өөр хоорондоо хамаарал маш багатай хараат бус ажилладаг байсан ба 1980-1990 –ээд оны хооронд энэ байдал нь компорацуудын сул тал болсон. Хэлтэс нэгж, салбар бүр эрсдэлийн удирдлагын ялгаатай хандлага, аргачлалуудтай, эрсдэлийн удирдлагын системгүй байснаас


¹ Азжаргал,М.Цагдаагийн байгууллагын эрсдэлийн удирдлага-Уб.,2019.5-6 дахь тал

² Цогтбадрах,П.Криминалистийн шинжээчийн үйл ажиллагаанд эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх арга зам-Уб.,2016. 6 дахь тал

алдаа дутагдал байнга гарч байснаас үүдэн байгууллагын бүх түвшинд нэгдсэн цогц эрсдэлийн удирдлагын бодлого хэрэгжүүлэх үе рүү шилжсэн.

Үр ашигтай эрсдэлийн удирдлага бүхий байгууллага гэнэтийн хохиролд цөөн өртөх ба ирээдүйн өсөлтийн боломж илүү сайтай байдаг. Эрсдэлийн удирдлагын процесс тухайн байгууллагын соёлд хэр сайн суусан байна, эрсдэлийн удирдлага төдий чинээ сайн байж, ирээдүйн сайн боломжууд руу хөтөлдөг.

Бүдүүвч 1., Эрсдэлийн удирдлагын процесс



Эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь байгууллагын холбогдох хууль тогтоомж, зохицуулах норм, дүрэм, журмын нийцэмжийг сайжруулахаас гадна зөв, зохистой шийдвэр гаргах болон төлөвлөх, нөөцийн хуваарилалтыг үр ашигтай хийх боломжийг бүрдүүлдэг.

Аливаа Улс, нийгмийн салбар, байгууллага бүрт тохирох эрсдэлийн удирдлагын бодлогын тогтсон нэг загвар гэж байхгүй. Харин эрсдэлийн удирдлагын бодлогод тухайн байгууллагын:

- Эрсдэлийн удирдлагын зорилго, зарчим болон үйл явц;
- Эрсдэлийг тодорхойлох, шинжлэх, удирдах, хянах аргачлал;
- Эрсдэлийн удирдлагын бүхий л шатанд оролцогчдын эрх үүрэг;
- Стратегийн бодлогын болон үйл ажиллагааны эрсдэлийг бүртгэх, тайлагнах, мэдээлэх үйл явц;
- Эрсдэлийн удирдлын тогтолцооны найдвартай байдал, байнгын сайжруулалтыг хангах арга зам зэргийг тодорхойлно.

Байгууллагын ажилтнуудын дунд эрсдэлийн удирдлагын бодлого, тогтолцооны талаарх ойлголт сайн байх тусам эрсдэлийн удирдлагын зарчим, үйл

явц үр ашигтай, үр дүнтэй хэрэгжиж, өдөр тутмын төлөвлөлт, гүйцэтгэлийн үйл ажиллагаанд нэвтрүүлэхэд хялбар байдаг.

Байгууллагын удирдлага тухайн байгууллагын үйл ажиллагааны онцлог, дотоод ба гадаад орчинд нийцсэн тогтолцоог бүрдүүлэхэд хичээх ёстой. Тогтолцоог бүрдүүлж, бодлогыг боловсруулахад дараах байдлаар одоо хэрэгжиж буй бодлого, журмыг баримтлах ёстой. Үүнд:

- Үндсэн үйл ажиллагаа;
- Тайлагнах механизм;
- Байгууллагын соёл;
- Ажиллах хүчний ур чадвар, чадавх;
- Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын үйл явц;
- Төсөв болон дэмжих нөөц, дэд бүтэц;
- Стандарт, хууль эрх зүйн болон зохицуулалтын шаардлагууд;
- Зохион байгуулалт, удирдлагын бүтэц;
- Эрх мэдэл, үүрэг хариуцлага, чиг үүрэг зэрэг болно.

Дээр дурдсаны дагуу эрсдэлийн удирдлага нь байгууллагын соёл, мөрдөгдөж буй засаглал дүрэм, журам, төлөвлөх, тайлагнах, шийдвэр гаргах тогтолцоотой уялдуулна.

Манай улсын цагдаагийн байгууллага нь эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх чиглэлээр дараах хууль, дүрэм, журмууд үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байна. Үүнд:

- Төрийн хяналт шалгалтын тухай хууль¹
- Гамшгаас хамгаалах тухай хууль(шинэчилсэн найруулга)²
- Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх журам³
- Монгол Улсын MNS ISO 31000:2020-Эрсдэлийн удирдлагын стандарт⁴
- Монгол Улсын MNS IEC 62305-2:2023-Эрсдэлийн менежмент⁵
- Монгол Улсын Засгийн газрын 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”⁶
- Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны 120 дугаар тушаалаар баталсан Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний харьяа агентлаг, байгууллагын “Эрсдэлийн үнэлгээ хийх аргачлал”⁷

¹ Төрийн хяналт шалгалтын тухай хууль-Уб.,2003.

² Гамшгаас хамгаалах тухай хууль-Уб.,2017.

³ Гамшгийн үнэлгээ хийх журам-Уб.,2020.

⁴ Монгол Улсын MNS ISO 31000:2020 “Эрсдэлийн удирдлагын стандарт”-Уб.,2020.

⁵ Монгол Улсын MNS IEC 62305-2:2023 “Эрсдэлийн менежмент”-Уб.,2023.

⁶ Монгол Улсын Засгийн газрын тогтоол “Дүрэм батлах тухай”-Уб.,2015.

⁷ Эрсдэлийн үнэлгээ хийх аргачлал-Уб хот., 2022.

- Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/295 дугаар тушаалаар баталсан “Ажлын байрны үнэлгээ хийх аргачилсан зөвлөмж”¹
- Сангийн сайдын 2019 оны А/268 “Улсын салбарын дотоод аудитын аргачлал”²
- Хууль зүйн сайдын 2013 оны А/248 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээний харьяа агентлаг, байгууллагын эрсдэлийн үнэлгээ хийх аргачлал”³
- Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх код-133 журам⁴ зэрэг үйлчилж байна.

Цагдаагийн байгууллага нь 2013 оноос эрсдэлийн удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх чиглэлээр дараах ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.Үүнд:

Нэг.Цагдаагийн байгууллагын хэмжээнд учирч болзошгүй онцлог эрсдэлүүдийг бодитой тодорхойлж, эрсдэл гарсан тохиолдол бүрийг үнэн зөв бүртгэх, эрсдэлийн түвшинг тодорхой тогтоох, ач холбогдлын зэрэглэлийн дагуу арга хэмжээ авч хэрэгжүүлэх, үр дүнд хяналт-шинжилгээ хийх, дахин эрсдэлээ тооцож, хэлбэлзлийг өмнөх жилүүдтэй харьцуулж хянахад чиглэсэн эрсдэлийн бүртгэлийг 2013 оноос эхлэн цагдаагийн төв байгууллага, түүний харьяа нэгж, алба, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын түвшинд бүртгэж хэвшсэн.

Хоёр.Цагдаагийн байгууллагын хэмжээнд эрсдэлийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг Хууль зүйн сайдын 2013 оны А/248 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээний харьяа агентлаг, байгууллагын эрсдэлийн үнэлгээ хийх аргачлал”, Сангийн сайдын 2015 оны 348 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Байгууллагын эрсдэлийн удирдлагад дотоод аудитыг нэвтрүүлэх заавар”, Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандарт 2120 “Эрсдэлийн удирдлага”, Практик зөвлөмж 2021-1 “Эрсдэлийн удирдлагын үйл явцын зохистой байдлыг үнэлэх”, 2012-2 “Дотоод аудитын нэгжийн эрсдэлийг удирдах”, СҮЗ-ийн 2011 оны 49 дүгээр тогтоолоор баталсан “Эрсдэлийн менежмент, зарчим ба заавар” MNS ISO 31000:2011 стандартад нийцүүлэн боловсруулж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлсэн.

¹ Ажлын байрны үнэлгээ хийх аргачилсан зөвлөмж-Уб.,2015.

² Аргачлал батлах тухай-Уб.,2020.

³ Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээний харьяа агентлаг, байгууллагын эрсдэлийн үнэлгээ хийх аргачлал-Уб.,2022

⁴ Цагдаагийн ерөнхий газрын даргын А/262 дугаар тушаал-Уб., 2024.

Гурав.Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд учирч болох эрсдэлийг зохицуулан удирдах, дотоод аудит хийх төлөвлөгөө боловсруулах дэг горимыг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх” код-137 журмыг баталж 2024 онд код-133 болгон өөрчлөн мөрдүүлсэн.

Дөрөв.Цагдаагийн байгууллагын зорилго, зорилтыг хангахад чиглэсэн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлох, хариу арга хэмжээг хэрэгжүүлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ирээдүйд учирч болзошгүй эрсдэлийн талаар удирдлагад мэдээлэх зорилгоор эрсдэлийн үнэлгээг цагдаагийн байгууллагын хэмжээнд хийж ХЗДХЯ-нд жил бүр хүргүүлж хэвшсэн.

Тав.Цагдаагийн байгууллагын эрсдэлийг тодорхойлох, эрсдэлийг үнэлэх, үнэлгээний мөрөөр төлөвлөсөн арга хэмжээг хэрэгжүүлэх, үр дүнг тооцох, хяналт шинжилгээ хийх үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг цагдаагийн байгууллагын хэмжээнд Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны Б/493 дугаар тушаалаар баталсан.

Цагдаагийн байгууллагын харьяа нэгжүүдийн түвшинд тухайн нэгжийн даргаар ахлуулсан эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх орон тооны бус баг ажиллаж өөрийн байгууллагын үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийн хариу арга хэмжээг зохион байгуулж, байгууллагын эрх мэдлийн хүрээнд эрсдэлийн хариу арга хэмжээг зохион байгуулж, үр дүнг тооцож эхэлсэн.

Харин байгууллагын эрх мэдлийн хүрээнд шийдвэрлэх боломжгүй, өндөр үнэлгээтэй эрсдэлүүдийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг дээд шатны байгууллагад эрсдэлийн үнэлгээний тайландаа тусган мэдээлж,тайлагнаж ирсэн.

Зургаа.Байгууллагын удирдлагын багаас тухайн нэгж дээрээ эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээний үр дүнг дараах шалгуураар үзүүлэлтүүдээр үнэлж, үнэлгээний мөрөөр хяналт шалгалт, дотоод аудитад хамруулан дотоод хяналтын үр нөлөөг нэмэгдүүлэхээр ажилласан. Үүнд:

- Байгууллагын зорилго, зорилтод эрсдэл учруулж болзошгүй нөхцөл байдлыг оновчтой тодорхойлсон байх(уг үйл явцад байгууллагын удирдлага, алба хаагч бүрийн оролцоог хангах);
- Эрсдэлийн бүртгэлийг үнэн зөв хөтөлж, эрсдэлийн мэдээллийн сан үүсгэсэн байх;
- Эрсдэлийн үнэлгээг магадлал, нөлөөллийн шалгуур үзүүлэлтийн дагуу эрсдэлийн бүртгэлд үндэслэн үнэн зөв, бодитой хийсэн байх;

- Эрсдэлийн үнэлгээний мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээг(эрсдэлийн менежментийн төлөвлөгөө) төлөвлөсөн байх;
- Төлөвлөгөөний биелэлт, үр дүнг хагас, бүтэн жилээр тооцсон байх;
- Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх орон тооны бус багийн үйл ажиллагааны үр дүнг тооцсон байх;
- Эрсдэлийн үнэлгээний тайланг тогтоосон хугацаанд ирүүлсэн байх гэсэн шалгуур үзүүлэлтээр байгууллагын дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын үр дүнтэй байдалд үнэлэлт өгч байна.

Шалгуур үзүүлэлтүүдийг хангаагүй тохиолдолд тухайн нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлсэн байдал, дотоод аудит, хяналт шалгалтад хамрагдсан давтамж, дотоод хяналтын орчин зэргийг харгалзан дотоод аудит болон хяналт шалгалтад хамруулж алдаа дутагдал, зөрчлийг арилгуулах, дахин давтан гаргахгүй байхад чиглэсэн ажил, арга хэмээг хэрэгжүүлэн ажилладаг.

Долоо.Цагдаагийн байгууллагын эрсдэлийн үнэлгээгээр их түвшинд үнэлэгдсэн эрсдэлүүдийг бууруулах арга хэмжээний саналыг Цагдаагийн байгууллагын удирдлагад танилцуулж, Хууль зүй, дотоод хэргийн сайдын дэргэдэх Дотоод аудитын хорооны хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлдэг.

Найм.Цагдаагийн ерөнхий газрын Хяналт шалгалт, үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс 2015-2019 онд эрсдэлийн удирдлагын чиглэлээр алба, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын нийт 2500 алба хаагчдад 100 удаагийн 220 цагийн сургалт, дадлагыг зохион байгуулж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажилласан.

Ес.Олон улсын стандартаар дотоод хяналтын бүтцэд эрсдэлийн удирдлага, хяналт шалгалт, аюулгүй байдал, мэдээлэл, харилцаа холбоо, хяналт-шинжилгээ, үнэлгээний чиг үүргүүд нь харьяалагдаж, дотоод аудит нь бие даасан хараат бусаар дотоод хяналтыг үнэлэх, байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлэхэд чиглэсэн баталгаажуулах, зөвлөх үйл ажиллагааг хэрэгжүүлж, байгууллагын удирдлагыг шийдвэр гаргахад боловсруулагдсан мэдээллээр хангахад чиглэгдсэн байхыг шаарддаг.Цагдаагийн байгууллагын хувьд эрсдэлд суурилсан дотоод аудитын тогтолцоог нэвтрүүлэх ажлын хүрээнд эрсдэлийн үнэлгээг харгалзан дотоод аудитын болон хяналт шалгалт явуулах төлөвлөлтийг хийж, гүйцэтгэлийг тооцож байна.

Арав.Цагдаагийн байгууллагын харьяа нэгж, байгууллагын хүсэлтийн дагуу тодорхой үйл ажиллагааны эрсдэлийг тодорхойлон үнэлж, хариу арга хэмжээг төлөвлөх, биелэлт, үр дүнг тооцоход мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх үйл ажиллагааг тогтмолжуулсан.Тухайлбал:

Нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүссэн, жагсаал цуглааныг албадан тараах үеийн үйл ажиллагаанд хийсэн эрсдэлийн үнэлгээ, хэсгийн байцаагчийн үйл ажиллагаанд хийсэн эрсдэлийн үнэлгээ, “Ази-Европын дээд түвшний арван нэгдүгээр уулзалт”(АСЕМ)-ын аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд хийсэн эрсдэлийн үнэлгээ зэрэг болно¹.

Цагдаагийн байгууллагын эрсдэлийг тодорхойлж үнэлэхэд Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны А/120 дугаар тушаалаар баталсан “Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний харьяа агентлаг, байгууллагын эрсдэлийн үнэлгээ хийх аргачлал”-ыг баримтлан байгаа нь олон улсад мөрдөгддөг COSO (Committee Of Sponsoring Organizations) загвар юм.

Энэхүү загварыг бид байгууллага, нэгжийнхээ эрсдэлийн үнэлгээг хийхэд ашигладаг ба дараах үйл явцаар хэрэгждэг.

Бүдүүвч 2.,Эрсдэлийг үнэлэх аргачлал

Эрсдэлийг үнэлэх



Байгууллага(Монгол Улсын Цагдаагийн байгууллага) эрсдэлээ дараах ангиллаар бодитой тодорхойлж байна.Үүнд:

- А. Нийцлийн буюу эрх зүйн зохицуулалтын эрсдэл;
- Б. Үйл ажиллагааны эрсдэл буюу гүйцэтгэл, зохион байгуулалтын эрсдэл;
- В. Хэрэгцээ шаардлага буюу төсөв, санхүүгийн эрсдэл;
- Г.Бусдаас хамааралтай буюу гадаад хүчин зүйлсийн эрсдэл;

Цагдаагийн байгууллагын эрсдэлийн удирдлагыг сайжруулах нь гэмт хэргийн гаралт, нийгмийн аюулгүй байдалд хяналт тавих, цагдаагийн ажилтнуудын аюулгүй байдал, байгууллагын үр ашгийг дээшлүүлэхэд чухал

¹ Азжаргал.М,мөн бүтээл.,18-20 дахь тал

үүрэгтэй байдаг. Энэхүү удирдлагын тогтолцоог сайжруулахад анхаарах хэд хэдэн асуудал байгаа бөгөөд эдгээр нь цагдаагийн байгууллагын дотоод үйл ажиллагаа, нийгмийн хариуцлага, эрсдэлийн менежментийн арга хэрэгсэлтэй холбоотой юм

Дүгнэлт

Цагдаагийн байгууллагад эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх чиглэлээр хэрэгжих буй хууль, дүрэм, журмын зохицуулалт хангалттай ба эрсдэлийн удирдлагын олон улсад мөрдөгддөг COSO (Committee Of Sponsoring Organizations) аргачлалаар эрсдэлээ тодорхойлж, удирдаж байгаа нь нэгэн хэвийн хэвшмэл загварт орсон.

Цагдаагийн байгууллага нь эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхдээ зөвхөн байгууллага, алба хаагчийн аюулгүй байдлыг хангах зорилгыг тавьж байгаа нь хангалтгүй бөгөөд гэмт хэргийн гаралт, нийгмийн аюулгүй байдалд хяналт тавих тогтолцоо, олон улсын эрсдэлийн удирдлагын аргачлалыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх шаардлагатай байна.

Санал

1. Төрийн болон нийгмийн орчинд эрсдэлийн үнэлгээ хийх

- *Гэмт хэргийн төрөл, давтамжийн судалгаа:* Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхдээ гэмт хэргийн төрөл, түүний гаралт, нийгмийн аюулгүй байдалд хэрхэн нөлөөлж буйг байнга судалж, эрсдэлийг үнэлэх хэрэгтэй.
- *Социологийн судалгаа:* Иргэдийн дунд цагдаагийн байгууллагын талаарх итгэл, ойлголт, харилцаа зэргийг үнэлэх нь бас чухал. Тухайлбал, хамтран ажиллах болон харилцан ойлголцол муу байх нь эрсдэлийг бий болгодог.

2. Технологийн хөгжлийг ашиглах

- *Мэдээллийн технологи (ИТ) болон өгөгдөлд суурилсан удирдлага:* Цагдаагийн байгууллагууд мэдээллийн технологийн дэвшлийг ашиглан гэмт хэргийн мэдээллийг хурдан шуурхай цуглуулах, шинжлэх, хяналт тавих системийг нэвтрүүлэх хэрэгтэй. Мөн цахим гэмт хэрэгтэй тэмцэхэд зориулсан технологийг хөгжүүлэх нь чухал.
- *Өгөгдлийн аюулгүй байдал:* Хэрэглэгчдийн хувийн мэдээлэл, гэмт хэргийн судалгааны өгөгдөл зэргийг хамгаалах нь байгууллагын үүрэг юм.

3. Цагдаагийн албан хаагчдын сургалт ба чадавхыг дээшлүүлэх

- *Төрөл бүрийн эрсдэлийн нөхцөл байдалд сургалт явуулах:* Ажлын байран дээр үүсч болох эрсдэлийг урьдчилан тооцоолох, ажилтнуудаа бэлдсэн байх нь чухал. Жишээ нь, мөрдөгч, шийдвэр гаргагч, гэмт хэрэгтэй тэмцэгчдийг тодорхой нөхцөлд хэрхэн ажиллахыг заах.
- *Психологийн дэмжлэг:* Цагдаагийн албан хаагчдын сэтгэл зүй, стрессийг зохицуулах сургалт, арга хэмжээнүүдийг явуулах нь ажилчдын бүтээмжийг нэмэгдүүлнэ.

4. Төрийн бодлого, хуулийн зохицуулалт

- *Эрсдэлийн удирдлагын хууль эрх зүйн орчныг сайжруулах:* Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг зохицуулах хууль, дүрэм журам, стандартуудыг шинэчлэн боловсруулж, өөрчлөлт, шинэчлэлтийг үр дүнтэй нэвтрүүлэх.
- *Төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах:* Төрийн бус байгууллагууд, иргэний нийгэмтэй хамтран ажиллах нь эрсдэлийн менежментийг нэмэгдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг.

5. Байгууллагын дотоод хяналт, үнэлгээ

- *Дотоод хяналт, шалгалт:*Цагдаагийн байгууллагын дотоод үйл ажиллагаанд тасралтгүй хяналт тавих, алдаа дутагдлыг илрүүлж, зохих арга хэмжээ авах нь эрсдэлийг бууруулахад чиглэнэ.
- *Оновчтой үнэлгээ ба хариуцлага:* Удирдлагын түвшинд тогтмол үнэлгээ, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүдийг ашиглан, албан хаагчдын ажлыг үнэлж, хариуцлага хүлээлгэх нь чухал.

6. Нийгэмтэй хамтран ажиллах

- *Иргэдтэй харилцаа:* Иргэдийн сэтгэл ханамжийг хангах, тэдний санал хүсэлтийг сонсох нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд чухал нөлөөтэй.
- *Нийгмийн сүлжээг ашиглах:* Гэмт хэргийн урьдчилан сэргийлэх, мэдээлэл түгээх зорилгоор нийгмийн сүлжээг ашиглах нь эрсдэлийг урьдчилан таньж, хянахад тусална.

7. Шинжлэх ухааны судалгаа, мэргэжлийн зөвлөмжийг ашиглах

- *Шинжлэх ухааны үндэслэлтэй арга барил:* Эрсдэлийн удирдлагын шинэ арга хэрэгслүүдийг судлах, гадаадын туршлагыг нэвтрүүлэх нь тус байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад чухал ач холбогдолтой.

Цагдаагийн байгууллагын эрсдэлийн удирдлагыг сайжруулах нь зөвхөн байгууллагын гүйцэтгэлийг дээшлүүлэх төдийгүй, гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн аюулгүй байдлыг хангах, хүний эрхийг хамгаалахад чухал үүрэг гүйцэтгэнэ. Тиймээс энэхүү чиглэлд байнга анхаарал хандуулах хэрэгтэй.

Эх сурвалжийн жагсаалт.

Нэг.Хууль, дүрэм, журам.

- 1.Төрийн хяналт шалгалтын тухай хууль-Уб.,2003.
- 2.Гамшгаас хамгаалах тухай хууль-Уб.,2017.
- 3.Гамшгийн үнэлгээ хийх журам-Уб.,2020.
- 4.Монгол Улсын MNS ISO 31000:2020 “Эрсдэлийн удирдлагын стандарт”-Уб.,2020.

5. Монгол Улсын MNS IEC 62305-2:2023 “Эрсдэлийн менежмент”-УБ.,2023.
6. Монгол Улсын Засгийн газрын тогтоол “Дүрэм батлах тухай”-УБ.,2015.
7. Эрсдэлийн үнэлгээ хийх аргачлал-УБ хот., 2022.
8. Ажлын байрны үнэлгээ хийх аргачилсан зөвлөмж-УБ.,2015.
9. Аргачлал батлах тухай-УБ.,2020.
10. Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээний харьяа агентлаг, байгууллагын эрсдэлийн үнэлгээ хийх аргачлал-УБ.,2022
11. Цагдаагийн ерөнхий газрын даргын А/262 дугаар тушаал-УБ., 2024.
12. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоол. “Алсын хараа 2050” урт хугацааны бодлогын баримт бичиг-УБ.,2020
13. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 141 дүгээр тогтоол. Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр-УБ.,2020.

Хоёр. Ном, судалгааны ажил, тайлан.

1. Азжаргал, М. Цагдаагийн байгууллагын эрсдэлийн удирдлага-УБ.,2019.
2. Цэвэл, Я. Монгол хэлний тайлбар толь-УБ.,1966.
3. Уэбстер, Н. Англи хэлний толь-1828
4. “Залуу судлаачдыг дэмжих сан ТББ”, Цагдаагийн албаны үйл ажиллагаан дахь иргэдийн сэтгэл ханамжийн түвшинг тодорхойлох судалгаа-УБ.,2023.
5. Максима судалгааны төв., Цагдаагийн ажиллах нөхцөл боломж, ажлын ачаалал, ажил мэргэжилдээ хандах хандлагын судалгаа-УБ.,2022.
6. Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2022, 2023 оны эрсдэлийн үнэлгээний тайлан.
7. Нурмаа, Т. Шүүхийн шинжилгээний байгууллагын үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан дотоод аудитыг хэрэгжүүлэх нь- УБ., 2019. 20 дахь тал
8. Цогтбадрах, П. Криминалистийн шинжээчийн үйл ажиллагаанд эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх арга зам-УБ.,2016. 6 дахь тал

Гурав. Цахим.

1. Доржнамжил, Д. Баярцэцэг, О. нар Эрсдэлийн удирдлагын арга түүний хэрэгсэл, хэрэглээ-УБ.,2013 он.,
https://prezi.com/pu839qwhg2/_presentation/
2. Эдийн засгийн дэлгэрэнгүй толь-УБ.,1998.
3. <https://en.wikipedia.org>.
4. Викитоль бичиг.